



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/114

Мандалговь

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр,
төсөл, арга хэмжээг төлөвлөх, эрэмбэлэх ажлыг
зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б”, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйл 65.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Гишүүд:	Г.Энхтайван	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Э.Чагнаадорж	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
	Ж.Түмэндэлгэр	(Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн)
	О.Мөнхзул	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Цэрэнханд	(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Худалдаа, үйлчилгээний албаны дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Уянга	(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
	Б.Энхтүвшин	(Тогтвортой амьжиргаа-3 төслийн ажилтан)
	Ж.Уянга	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтын төслийг бэлтгэж иргэд, олон

481210315

нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан тэдний эрх ашигт нийцсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, холбогдох журмын шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ